

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ  
2019 ОНЫ 03 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЕЛЭЛТ**

2019 оны 04 дүгээр сарын 02

Багануур дүүрэг

№	Үндэслэл	Хийсэн ажлын биелэлт	Гүйцэтгэлийн хувь
1	“БҮТП” ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.2	Парк-Суралцагч байгууллага болох зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу: <ul style="list-style-type: none"> <li>• Паркийн зүгээс 2019 онд хэрэгжүүлэх инновацийн төлөвлөгөө гарган ажилтан бүрийн санаачилга оролцоог нэмэгдүүлэх талаар ярилцлага зохион байгуулсан.</li> <li>• Аливаа хөтөлбөр төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хөдөлмөр зохион байгуулалтын инноваци нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн.</li> </ul>	100%
2	“БҮТП” ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.2.	Газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 26-ний өдрийн А/04 тушаалын хэрэгжилтийг хангах үүднээс нээлттэй сонгон шалгаруулалтын ажлын хэсэг сарын хугацаанд ажиллаа. Доорх дөрвөн орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулж 14 хоногийн хугацаатай байгууллагын болон ХХҮХ-ийн вэб сайтад зар байршуулсан. <ul style="list-style-type: none"> <li>• Эрдэм шинжилгээ, судалгааны төвийн конструктор инженер,</li> <li>• Үйлдвэрлэл, технологийн кластер инженер,</li> <li>• Төсөл, хөрөнгө оруулалт хариуцсан эдийн засагч,</li> <li>• Программ хангамж, бүртгэл, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн</li> </ul> Ажлыг хэсэг хуралдаж газрын даргад саналаа хүргүүлсэн бөгөөд шинээр үүссэн орон тоонд ажлын байрны тодорхойлолт боловсруулж баталсан.	100%
3	“БҮТП” ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 7.1.	Байгууллагын дотоод сүлжээ, интернет холболтын хурд, мэдээллийн сүлжээний хамгаалалтын найдвартай ажиллагааг хангаж ажилласан.	100%
4	“БҮТП” ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 17.1.	Мон – Энержи Консалт” ХХК-ийн гүйцэтгэж байгаа паркийн бүсүүдийн дэд бүтцийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, гадна инженерийн шугам сүлжээний төслийн гүйцэтгэлд хяналт тавих ажлын хүрээнд дэд бүтцийн инженер Б.Мөнгөнхуяг 2019.03.21-22-ны өдрүүдэд зураг төслийн ажлын явц болон техникийн нөхцөлийн талаар гүйцэтгэгч компанитай уулзаж, хамтарч ажилласан. Мөн гүйцэтгэгч байгууллагаас дулаан болон цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийг авах тухай хүсэлтийг ЭХЯ-нд хүргүүлсэн.	100%
5	“БҮТП” ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 12.1	Дүүргийн жижиг дунд үйлдвэрүүдийг дэмжиж, хөгжүүлэх чиглэлээр ЖДҮДТ–тэй 2019.03.22-ны өдөр хамтран ажиллах санамж бичиг байгуулан төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.	100%




6	"БҮТП" ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 8.1	МУИС болон ШУТИС-ийн удирдлагуудтай уулзаж, хамтран ажиллах гэрээ байгуулахаар гэрээний төсөл, үйл ажиллагааны чиглэлүүдийг хүргүүлсэн.	100%
7	"БҮТП" ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 9.1.	Паркад ургамлын биотехнологийн үйлдвэрлэлийг байгуулах суурь судалгааг үргэлжлүүлэх ажлын хүрээнд ЕБСБХ болон УХЭШХ-тэй хамтран ажиллах чиглэлээр уулзалт зохион байгуулж, гэрээний төслийг хүргүүлсэн бөгөөд гэрээ байгуулахаар хүлээгдэж байна.	80%
8	"БҮТП" ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 21.1.	Байгууллагын нийгмийн хариуцлагын хөтөлбөр боловсруулж баталсан.	100%
9	"БҮТП" ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 10.1	Эрдэм шинжилгээний байгууллага, тариаланчид, үйлдвэрлэгчид, иргэдийг хамруулсан "Эмийн ургамал, жимс жимсгэнэ тариалах" сэдэвт сургалт, зөвлөгөөнийг 2019.03.22-нд дүүрэгтээ зохион байгуулсан.	100%
<b>Нэмэлт ажлууд</b>			
10	Нийслэлийн төрийн аудитын газраар байгууллагын 2018 оны санхүүгийн тайланг шалгуулж зөрчилгүй санал дүгнэлтийг аудитын тайлан, гэрчилгээний хамт авсан.		100%
11	2019.03.06-ны өдөр Нийслэлийн архивын газар болон Багануур дүүрэг хамтран "төрийн албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа болон edoc системийн ашиглалт хэрэглээг сайжруулах нь" сэдэвт сургалтад бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн Мөнхдуламыг хамруулсан.		100%
12	2019.03.22-нд дүүргийн ХАА албанаас зохион байгуулсан худалдан авах ажиллагааны АЗ сертификат олгох сургалтад эдийн засагч, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Б.Мичид-Эрдэнийг хамруулсан.		100%
13	Монгол улсын Үндэсний хөгжлийн газар болон GIZ ЭТИС хөтөлбөр хамтран "Жижиг, дунд бизнесийн инновациудыг дэмжих сан", "Залуу эрдэмтэд, гарааны бизнесийн инновациудыг дэмжих сан", "Бүтээлч сэтгэлгээ, медиа болон цахимжуулалтын төрлийн инновациудыг дэмжих сан" байгуулсан бөгөөд эдгээр сангуудын үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд инновацийн урьдчилсан дөрвөн төслийг боловсруулж 02.14-ны өдөр Нийслэлийн Инновацийн санд хүргүүлсний үр дүнд дараах 2 төсөл эхний шалгаруулалтад тэнцсэн. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар компост бордоо хийх үйлдвэр</li> <li>• Багануурын нүүрсний уурхайн овоолгын шорооноос будаг гаргах үйлдвэр</li> </ul>		100%
14	Нийслэлийн ЗДТГ-ын ХШ,ҮХ-т байгууллагын 1 дүгээр улирлын бүх тайланг хүргүүлсэн. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Төрийн албаны сахилга хариуцлага дэг журмыг чангатгах ажлын төлөвлөгөөний 1 дүгээр улирлын биелэлт</li> <li>• Нийслэлийн ЗД-ийн 2016-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1 дүгээр улирлын биелэлт</li> <li>• Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1 дүгээр улирлын биелэлт</li> <li>• Нийслэлийн Засаг даргын захирамжийн 1 дүгээр улирлын биелэлт</li> <li>• Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 1 дүгээр улирлын хэрэгжилтийн биелэлт, дүн, хяналт шинжилгээ үнэлгээ, даргын зөвлөлийн хурлын протокол</li> <li>• Байгууллагад иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын 1 дүгээр улирлын мэдээ</li> </ul>		100%



	<ul style="list-style-type: none"> <li>• Байгууллагын удирдлагын иргэдтэй уулзсан уулзалтын 1 дүгээр улирлын тайлан</li> </ul>	
15	<p>Багануур дүүргийн ЗДТГ-ын ТЗУХ-т байгууллагын 1 дүгээр улирлын бүх тайланг хүргүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Багануур дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1 дүгээр улирлын биелэлт</li> <li>• Багануур дүүргийн 2019 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1 дүгээр улирлын биелэлт</li> <li>• Багануур дүүргийн Засаг даргын захирамжийн 3 дугаар сарын биелэлт</li> </ul>	100%
16	Үндэсний хөгжлийн газрын хөрөнгө оруулалт хариуцсан ахлах мэргэжилтэн Түмэндэлгэрт байгууллагын танилцуулга болон дэд бүтцийн бүтээн байгуулалтын тооцоог илгээсэн.	100%
17	2020 онд Багануур дүүргийн 40 жилийн ойг тэмдэглэх ажлын хүрээнд “Багануур 40 жил – 40 инноваци” аянд паркаас зохиох ажлын саналыг ЗДТГ-ын ТЗУХ-т хүргүүлсэн.	100%
18	МУ-ын Засгийн газрын 2019 оны 37,38 дугаар тогтоолын дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлан НЗДТГ-ын ХШ,ҮХ-т хүргүүлсэн.	100%
19	Багануур дүүргийн Захирагчийн ажлын албанаас 2019.03.26-ний өдөр ирүүлсэн 2/54 албан бичгийн дагуу “БИДНИЙ ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ” сэдэвт сар бүрийн 9-ний өдөр зохион байгуулах арга хэмжээний саналыг боловсруулж хүргүүлсэн.	100%
20	Монголын цахилгаан холбоо” ТӨХК-аас IP эрх авч байгууллагын цаг бүртгэлийн төхөөрөмжийг “UB ERP” системийн цаг бүртгэлийн дэд системд холбосон. Мөн нийслэлийн “UB ERP” системийг байгууллагын дотоод удирдлагын үйл ажиллагаандаа бүрэн ашиглаж эхэлсэн бөгөөд албан хаагчдын хэрэглээг жигдрүүлэхээр ажиллаж байна.	100%

ХЯНАСАН:

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:



*С. Мичид-Эрдэнэ*

Ч.ЭЛБЭГСАЙХАН

“Багануур Үйлдвэрлэл, Технологийн Парк” ОНӨТҮГ-ын дарга

Д.Алтангэрэл

Ахлах мэргэжилтэн

Б.Мичид-Эрдэнэ

Эдийн засаг, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн